



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 14 өдөр

Дугаар А/190

Хархорин сум

Эзэмшил газрын зориулалт өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсэг, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 8.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэр Өл 10-31 тоотод иргэн А.Отгонбаярын гэр, орон сууцны хашааны газрын зориулалтаар эзэмшиж байгаа 6209005601 нэгж талбарын дугаартай 649м<sup>2</sup> газрыг эзэмшигчийн хүсэлтийн дагуу үйлчилгээтэй орон сууцны зориулалттай болгон өөрчилсүгэй.

2.Газар эзэмигч А.Отгонбаярт газар эзэмших эрхийн эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (А.Норпил), (Ч.Баттулга) нарт даалгасугай.

3.Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, газрыг зориулалтын дагуу эзэмших, газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн барагдуулж байх, Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг (А.Отгонбаяр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ОДГЭРЭЛ

491190379